

# МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

## Ангилалтын код. 13.100

**Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугиан хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага.**  
**General requirements for the measurements of noise.**

**MNS 5003:2000**

Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн Зөвлөлийн 2000 оны 12-р сарын 21 өдрийн 146 тоот тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2000 оны 12-р сарын 31-ний өдрөөс эхлэн хүчинтэй. Энэ стандартын шаардлагыг заавал мөрдөнө.

## 1 ХАМРАХ ХҮРЭЭ

Энэ стандарт нь өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байрны бүсэд шуугианы хэмжилт хийхэд тавигдах ерөнхий шаардлагыг тогтооно.

## 2 ХЭМЖИХ ПАРАМЕТР

- 2.1 Шуугианы эквивалент даралтын түвшин, / дБА /.
- 2.2 Октавын бүсүүдийн дууны даралт, /дБС/.
- 2.3 Шуугианы параметрийг хэмжихдээ зориулалтын тусгай багаж / DIGITAL SOUND METER г.м /-ыг ашиглана.

## 3 ШУУГИАН ХЭМЖИХЭД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 3.1 Ажлын байрны бүсэд шуугианы түвшин эрүүл ахуйн зөвшөөрөгдөх норм хэмжээнд байгаа эсэхэд хяналт тавих зорилгоор хэмжилт хийнэ.
- 3.2 Хэмжилтийн дүн нь ажлын ээлжийн / ажлын өдөр / хугацаанд суурилуулсан техник, тоног төхөөрөмж, технологийн үйл ажиллагаа зонхилох горимоор ажиллаж байгаа үед шуугианы үйлчлэлийг тодорхойлж байх ёстой.
- 3.3 Хэмжилт хийх үед ажлын байранд байрлуулсан байнга ашигладаг, шуугиан үүсгэгч болдог агааржуулалт, агаар чийгшүүлэгч зэрэг бусад тоног төхөөрөмжийг ажиллуулсан байх ёстой.
- 3.4 Шуугианы хэмжилтийн үр дүнд нөлөөлөх доргио, цахилгаан ба соронзон орон, радио идэвхит бодис зэрэг физик хүчин зүйлийн үйлчлэлийг тооцсон байх ёстой.
- 3.5 Салхины үйлчлэлээс хамгаалж дуу шуугианы долгиог хүлээн авагчид / микрофон / зориулалтын хамгаалалтыг хийж өгнө.
- 3.6 Хэмжилтийн багажийг ашиглахын өмнө ашиглалтын зааврын дагуу тохируулга хийж баталгаажуулсан байна.

## **MNS 5003:2000**

**3.7** Тогтмол биш шуугианыг хэмжихдээ ажлын ээлжийн хугацааны хагас буюу технологийн нэг бүтэн мөчлөг явагдах хугацааны турш хэмжинэ.

**3.8** Хэлбэлзэлт шуугианы хувьд хэмжилт тус бүр нь 10 минут үргэлжилсэн гурван хэмжилт хийх бөгөөд хэмжилт хийх нийт хугацаа 30 минутаас бага байж болохгүй.

**3.9** Нэг ажлын байранд 3-аас доошгүй удаа хэмжилт хийж, шуугианы хэмжилтийн үзүүлэлтийн дунжийг гарган хэмжилтийн үр дүнг тооцно.

**3.10** Тасралттай шуугианы хувьд шуугианы гол үйлчлэлийн нэг бүтэн мөчлөгийн хугацаанд хэмжилтийг хийнэ.

**3.11** Шуугианы долгиог хүлээн авагчийг шуугианы үйлчлэлд өртөж байгаа хүний ажлын байранд босоо ажлын үед шалнаас 1,5 м өндөрт, суугаа ажлын үед чихний түвшинд хүнээс 0,5м-ээс багагүй зайд байрлуулна.

**3.12** Байнгын ажлын байранд шуугианыг урьдчилан сонгон авсан цэгүүдэд хэмжинэ.

**3.13** Байнгын биш ажлын байранд шуугианыг хэмжихдээ ажиллагсад хамгийн их өртөж байдаг ажлын бүсэд дууны долгион хүлээн авагчийг байрлуулан хэмжинэ.

**3.14** Шуугианы түвшин, шуугианы эквивалент түвшинг хэмжихдээ багажийн "А" гэсэн байрлалд тавина.

**3.15** Тогтмол шуугианы түвшинг хэмжихдээ багажийн хугацааны үзүүлэлтийн "удаан" гэсэн байрлалд тавина. Хэмжилтийн дундаж заалтыг шуугианы түвшний утга болгож авна.

**3.16** Хэлбэлзэлт шуугианы түвшинг хэмжихдээ багажийн хугацааны үзүүлэлтийн "удаан" байрлалд тавьж хэмжинэ.

**3.17** Хэлбэлзэлт шуугианы хамгийн их түвшинг хэмжихдээ багажийн үзүүлэлтийн " оргил " гэсэн байрлалд тавина. Хамгийн их заах утгыг шуугианы түвшин болгон авна.

**3.18** Тогтмол биш шуугианы эквивалент түвшинг хэмжихдээ багажийн хугацааны үзүүлэлтийн "удаан" байрлалд тавьж, шуугианы түвшний утгын үе шат бүрийн үргэлжлэх хугацааг хэмжинэ.

**3.19** Шуугианыг хэмжихдээ А. хавсралтаар үзүүлсэн маягт хөтөлж, хэмжилтийн дүнг бичнэ.

**ТӨГСӨВ.**

**ШУУГИАНД ХЭМЖИЛТ ХИЙСЭН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ**

Хэмжилт хийх аж ахуйн нэгж, байгууллагын нэр-----  
-----

Хаяг-----  
-----

Утас----- Факс-----  
-----

Хэмжилт хийсэн ажлын байр-----  
-----

Шуугианы шинж байдал, шуугианы гол үүсгүүрүүд:-----  
-----  
-----

Хэмжилт хийсэн ажилтны овог, нэр-----  
-----

Албан тушаал-----  
-----

Хэмжилт хийхэд мөрдсөн стандартын дугаар-----  
-----

Хэмжилт хийсэн он, сар, өдөр-----  
-----

Хэмжилт хийсэн ажлын байр	Шуугианы шинж байдал				Дууны даралтын түвшин, дБ, октавын бүсүүдийн геометр дундаж давтамж, Гц								Шуугианы түвшин, дБА /эквивалент/	Шуугианы хамгийн их түвшин, дБА	Зөвшөөрөгдөх хэмжээ /норм/
	1 Тогтмол	2 Хэлбэлзэлт	3 Тогтмол биш	4 Импульт	5 63	6 125	7 250	8 500	9 1000	10 2000	11 4000	12 8000			
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15